



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/568

Булган сум

**Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.6, 9.9 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн А/179 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын бруцеллёз өвчинтэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс зохион байгуулсугай.

2. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах малын тоо, шаардагдах вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалтад шаардагдах вакцин, био бэлдмэлийг татан авч сумдад хувиарлан олгох, сумын мал эмнэлэг, малын эмч нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), дархлаажуулалтын ажлыг орон нутагт зохион байгуулан удирдлага, хүн хүч, машин техник, бусад шаардлагатай зүйлээр хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулсан дүн мэдээг нэгтгэн 2023 оны 10 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргад танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010623